



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 17/32-02

Сүхбаатар сум

Шаамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
ажлын албаны Санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2025 оны дугаар 03 сарын 05-ны өдрийн 18 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Шаамар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Шаамар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны (цаашид сумын Шаамар сумын ИТХ гэх)-ын 2023, 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Шаамар сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3763897 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131254001 дугаартай үндсэн данс 10013121254401 дугаартай нэмэлт дансыг ашиглаж байна.

1.5. Шаамар сумын ИТХ-ын төсвийн орлого, тайлан, төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн даргыг Б.Дариймаа 2-р гарын үсгийг нягтлан бодогч А.Раднаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.6. Шаамар сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 1 багийн иргэдийн нийтийн хурлын 2 нийт 4 албан хаагч үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 онд 89 хувь, 2024 онд 85.3.0 хувь, сумын ИТХ-ын даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2023 онд 91 хувь, 2024 онд 90.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд орон нутгийн төсвөөс 116,349.1 мянган төгрөгөөр 2024 онд 149,436.0 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2023 онд 94,161.6 мянган төгрөгийг буюу 81 хувийг , 2024 онд 124,980.5 мянган төгрөгийг буюу 84 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	2023 онд			2024 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,349.1	94,161.6	22,187.5	149,436.0	124,980.5	24,455.5
2	УРСГАЛ ЗАРДАЛ	116,349.1	94,161.6	22,187.5	149,436.0	124,980.5	24,455.5
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,449.1	92,261.6	22,187.5	149,436.0	124,980.5	24,455.5
А	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,061.0	59,612.5	7,448.5	110,520.2	91,416.4	19,103.8
1	Үндсэн цалин	42,964.2	39,532.7	3,431.5	85,194.9	53,368.0	31,826.9
2	Нэмэгдэл	16,565.0	14,940.7	1,624.3	12,525.5	29,545.5	-17,020.0
3	Урамшуулал	7,531.8	5,139.1	2,392.7	12,799.8	8,502.9	4,296.9
4	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,552.1	7,458.0	1,094.1	14,583.2	10,194.2	4,389.0
5	Тэтгэврийн даатгал	5,840.1	5,016.8	823.3	9,724.5	6,561.8	3,162.7
6	Тэтгэмжийн даатгал	677.8	592.9	84.9	1,135.2	996.3	138.9
7	ҮОМШӨ-ний даатгал	542.5	546.4	-3.9	908.1	540.4	367.7
8	Ажилгүйдлийн даатгал	135.4	121.6	13.8	545.0	464.5	80.5

9	Эрүүл мэндийн даатгал	1,356.3	1,180.3	176.0	2,270.4	1,631.3	639.1
10	Хангамж, бараа материалын зардал	6,781.6	5,761.5	1,020.2	14,432.1	14,432.1	0.0
11	Бичиг хэрэг	1,685.2	1,281.5	403.8	2,821.2	2,821.2	0.0
12	Тээвэр, шатахуун	1,764.9	1,764.9	0.0	4,673.8	4,673.8	0.0
14	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713.9	178.7	535.2	480.0	480.0	0.0
16	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,617.6	2,536.4	81.2	6,457.1	6,457.1	0.0
17	Нормативт зардал	58.8	0.0	58.8			
18	Нормын хувцас, зөөлөн эдлэл	58.8	0.0	58.8			
19	Эд хогшил, урсгал засварын зардал	3,776.4	3,775.0	1.4	5,000.0	4,804.5	195.5
20	Багаж, техник, хэрэгсэл	3,776.4	3,775.0	1.4	1,860.4	1,860.4	0.0
21	Тавилга				2,139.6	2,000.1	139.5
22	Урсгал засвар				1,000.0	944.0	56.0
23	Томилолт, зочны зардал	1,370.4	0.0	1,370.4	500.0	133.3	366.7
24	Дотоод албан томилолт	1,370.4	0.0	1,370.4	500.0	133.3	366.7
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,228.1	12,830.7	1,397.4	4,400.5	4,000.0	400.5
26	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,956.8	12,830.7	1,126.1	4,000.0	4,000.0	0.0
28	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108.0	0.0	108.0	184.6	0.0	184.6
29	Даатгалын үйлчилгээ	102.1	0.0	102.1	122.4	0.0	122.4
30	Тээврийн хэрэгслийн татвар	34.5	0.0	34.5	52.5	0.0	52.5
31	Тээврийн хэрэгслийн оношлогоо	26.7	0.0	26.7	41.0	0.0	41.0
32	Бараа үйлчилгээний бусад зардал	12,620.7	2,824.0	9,796.8	0	0	0
33	Бараа үйлчилгээний бусад зардал	9,736.1	0.0	9,736.1	0	0	0
34	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,884.6	2,824.0	60.7	0	0	0
35	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,900.0	1,900.0	0.0	0	0	0
36	Бусад урсгал шилжүүлэг	1,900.0	1,900.0	0.0	0	0	0
37	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,900.0	1,900.0	0.0	0	0	0
Б	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,349.1	94,161.6	22,187.5	149,436.0	124,980.5	24,455.5

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

1. **Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2023 онд 67,061.0 мянган төгрөг 2024 онд 110,520.2 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2023 онд 59,612.5 мянган төгрөгийг зарцуулж 7,448.5 мянган төгрөгийг хэмнэж 2024 онд 91,416.4 мянган төгрөгийг

- зарцуулж 19,103.8 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь зарим сард орон тоо гүйцэд биш ажилласнаас шалтгаалсан байна.
2. **Хангамж бараа материалын зардал:** 2023 онд хангамж, бараа материалын зардалд 6,781.6 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 1,1281.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1,764.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 178.5 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2,536.4 мянган төгрөг зарцуулж 1,020.2 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд хангамж, бараа материалын зардалд 14,432.1 мянган төгрөг батлагдаж 100 хувь зарцуулсан зарцуулсан байна.
 3. **Томилолтын зардал:** 2023 онд 1,370.0 мянган төгрөг батлагдаж 100 хувь, 2024 онд 500.0 мянган төгрөг батлагдаж 133.0 мянган төгрөг зарцуулж 366.7 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
 4. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2023 онд 14,228.1 мянган төгрөг батлагдсанаас 12,830.7 мянган төгрөг зарцуулж 1,397.4 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд 4,000.0 мянган төгрөг батлагдаж 100хувь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулж БГАҮ-ний зардалд тайлагнасан байна.
 5. **Бусад зардал:** 2023 онд 9,736.1 мянган төгрөг батлагдаж 100 хувь зарцуулж 2024 онд зардал төсөвлөөгүй учраас ажил гүйлгээ гараагүй байна.
 6. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2023 онд нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1,900.0 мянган төгрөг батлагдаж 100 хувь зарцуулж 2024 онд зардал төсөвлөөгүй учраас ажил гүйлгээ гараагүй байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2023,2024 онуудад сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

Сумын ИТХ-ын ажлын алба нь 4 орон тоотойгоор үйл ажиллагааг батлагдсан нийт төсвийн 2023 онд 67,061.0 мянган төгрөг буюу 58 хувь, 2024 онд 91,416.4 мянган төгрөг буюу 74 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөсөн байна. 2023 онд 59,612.5 мянган төгрөгийг буюу 64 хувийн, 2024 онд 91,416.4 мянган төгрөг буюу 83 хувийг цалин хөлс, нэмэгдэл хөлс олгоход зарцуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2024 оны нийт цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардал өмнөх оноос 24 хувиар нэмэгдсэн байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгаж үзэхэд илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

2.4 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2023, 2024 онуудад төсвийн хөрөнгөөр ажил үйлчилгээ, бараа материал худалдан шууд худалдан авах босго үнээс давсан томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

2.5. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023,2024 онуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт гараагүй түүвэрт хамрагдсан ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил илрээгүй

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Шаамар сумын ИТХ-ын ажлын албаны 2023,2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл хөтлөлт, шатахууны норм, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил дутагдал илэрлээ,

Илрүүлэлт 1 Жолоочийн тооцооны хуудсыг маягыг ажилд гарсан тухай бүрээр нь хөтлүүлээгүй сараар болон хагас жилээр бөөн дүнгээр замын хуудас бичүүлж ./2023 онд 2,964.9 мянган төгрөг, 2024 онд 4,673.8 мянган төгрөгийн нийт 7,638.7 мянган төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг ажилд гарсан тухай бүрд нь километрийн заалтыг бичүүлж шатахууныг сар бүр тооцож тайлангнах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2. ИТХ-ын төлөөлөгч нар хуралд суусан ирцийн бүртгэл дутуу, хоолны зардлын төсөв хийгээгүй зардлын тайлан хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 8,148.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Томилолтын зардлаас 133.3 мянган төгрөгийг ХАОАТ-ын шимтгэлд зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана, 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэлт Төсвийн зарлагыг хууль, эрхийн актад нийцүүлэн үнэн зөв төлөвлөж зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Үйл ажиллагааны урсгал зардлаас ИТХ-ын төлөөлөгч нарт хуралдаа ирж суух буцах шатахууны зардалд 543.3 мянган төгрөгийн зарцуулж ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулан ИТХ-ын төлөөлөгч нарт хуралд ирэх, буцах шатахууныг цаашид олгохгүй байхыг зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,160.4 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох бараа материалын дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 дахь “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.3.1-т заасан “Бараа материалын бүртгэл” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,160.4 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох бараа материалын дансанд бүртгэх зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Шаамар сумын ИТХ-ын 2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд ” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Шаамар сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **17,606.4** мянган төгрөгийн **5** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 8,281.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9,324.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт даалгав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ШААМАР СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Д.НАРАНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ



А.РАДНАА